350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,045,600.00	52,922,144.14
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	469,300,900.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	265,049,752.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	297,536,603.24
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>112.00</b>	<b>54.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>55.00</b>	<b>26.00</b>
620001	Удирдах ажилтан	10.00	10.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	32.00	3.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>55.00</b>	<b>26.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	36.00	7.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>81,877,062.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>81,877,062.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>69,633,528.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,736,000.00</b>
210101	Үндсэн цалин	1,370,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	366,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>175,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	175,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,825,153.00</b>
210401	Бичиг хэрэг	773,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,475,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	229,025.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	632,388.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,715,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,310,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	160,100.00
210502	Хоол, хүнс	4,150,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,031,275.00</b>
210604	Урсгал засвар	11,031,275.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,556,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,556,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,243,534.20</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,243,534.20</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,428,852.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,814,682.20
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>80,448,210.20</b>

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>80,448,210.20</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрсөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,376,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,956,040.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,115,810.20
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-1,428,852.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,428,852.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус байгууллага нь “Монгол улсын хуулийг дээдлэн хэрэгжүүлж, Засгийн газрын шийдвэр, аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангасан, төсвийн болон шилэн дансны тухай хууль ОУНББ-н стандартын дагуу төсөв санхүүг оновчтой зарцуулж чанарын удирдлагын тогтолцоо ISO-9001 стандарт болон байгууллагын цахим удирдлагын цогц системийг бүрэн нэвтрүүлсэн шуурхай хариуцлагатай захирах захирагдах зарчмыг баримталсан, зөв боловсон харилцаатай, угтах үйлчилгээ нь хэвшил болсон байгууллагын соёл, багаар ажиллах чадвар төгөлдөржсөн тэргүүний хамт олон болох” зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, чадварлаг мэргэшсэн хамт олныг бүрдүүлэх, орон нутгаа хөгжүүлэх
- Орон нутгийн онцлогт тохируулсан хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн манлайлагч захиргааны байгууллага болох
- Сум орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой ахиулах замаар иргэдийнхээ хөгжих боломжийг хангаж, тогтвор суурьшилтай амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэн, төрийн үйлчилгээг стандартад нийцүүлэн чанартай хүргэнэ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Нийгмийн даатгалын тухай хууль Татварын тухай хууль Төрийн албаны тухай хууль Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын 2022 оны санхүүгийн тайлан дахь Тайлант онд баталсан татварын болон татварын бус орлогыг мөнгөн сууриар хөтөлж, ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,366.6 сая төгрөгөөр буюу 68.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	470.54	365.66	(104.88)
Авлага	503.52	123.80	(379.72)
Бараа материал	289.70	46.51	(243.19)
Үндсэн хөрөнгө	5,085.90	1,186.85	(3,899.05)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,349.66</b>	<b>1,983.01</b>	<b>(4,366.64)</b>
Өр төлбөр	138.95	2.36	(136.58)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,210.71	1,980.65	(4,230.06)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,349.66</b>	<b>1,983.01</b>	<b>(4,366.64)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 68.8 хувиар буурсан нь Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллага”-ын төсвийг БЕГ-ын даргад шилжүүлж системийн бодлогын өөрчлөлт орсонтой холбоотойгоор буурчээ.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 365.7 сая төгрөг болж, өмнөх оноос 104.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	470.54	365.66	(104.88)
<b>Төгрөг</b>		365.66	365.66
Төрийн сангийн харилцах	469.11	365.66	(103.45)
Арилжааны банк дахь харилцах		-	-
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1.43	-	(1.43)
<b>Гадаад валют</b>		-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
<b>Дүн</b>	<b>470.54</b>	<b>365.66</b>	<b>(104.88)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 365.6 сая төгрөг нь Сайхан сумын төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа ОНЕО-ын дансанд 68,125.6 мянган төгрөг, ОНХС-д 84,170.8 мянган төгрөг, Сум хөгжүүлэхийн дансанд 199,414.7 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангийн дансанд 461.9 мянган төгрөг, ЖДҮД сангийн дансанд 13,489.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 123.8 сая төгрөг болж, өмнөх оноос 468.7 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.06	-	(0.06)
Төлбөртэй үйлчилгээний авлага	308.32	-	(308.32)
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
<b>Зээлийн хүүгийн авлага</b>	<b>1.56</b>	<b>11.39</b>	
Дансны авлага /ТӨҮГ/	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
<b>Бусад авлага</b>	<b>193.57</b>	<b>33.24</b>	<b>(160.33)</b>
Байгууллагаас авах авлага	32.22	13.10	(19.12)
Хувь хүмүүсээс авах авлага	161.35	20.14	(141.21)
<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>-</b>	<b>79.16</b>	<b>79.16</b>
Хувь хүмүүст олгосон зээл		79.16	79.16
<b>Дүн</b>	<b>503.51</b>	<b>123.80</b>	<b>(468.71)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Авлагын үлдэгдэлд 5-с дээш жилийн насжилттай 123,796.0 төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Зээлийн хүүгийн авлагаар Сум хөгжүүлэх санд 9,831.9 мянган төгрөгийн, ЖДҮДС-д 1,562.6 мянган төгрөг үүссэн нийт 11,394.5 мянган төгрөгийн авлага,
- Бусад авлагаар Сум хөгжүүлэх санд 6,764.9 мянган төгрөг, ЗДТГ-д 16,152.7 мянган төгрөг, ЖДҮДС-д 10,320.3 мянган төгрөг нийт 33,237.9 мянга төгрөгийн авлага
- Зээлийн авлагаар Сум хөгжүүлэх санд 79,163.7 мянган төгрөгийн авлага

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг байна.

#### Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Урьдчилгаа тооцоо	0	0	0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0	0	0
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 46.5 сая төгрөг болж, өмнөх оноос 243.2 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>138.93</b>	<b>0.94</b>	<b>(137.99)</b>
Тусгай зориулалттай материал	11.83	0.94	(10.89)
Эм боох материал	127.10	-	(127.10)

Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
<b>Хангамжийн материал</b>	146.71	<b>41.51</b>	<b>(105.20)</b>
Бичиг хэргийн материал	3.64	0.21	(3.43)
Аж ахуйн материал	116.22	16.22	(100.00)
Сэлбэг хэрэгсэл	-	10.33	10.33
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	0.25	-	(0.25)
Хүнсний материал	21.03	-	(21.03)
Бусад хангамжийн материал	5.57	14.76	9.19
<b>Мал амьтад</b>	<b>4.06</b>	<b>4.06</b>	-
<b>Дүн</b>	<b>289.70</b>	<b>46.51</b>	<b>(243.19)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Тайлант онд ЗДТГ 120,056.1 мянган төгрөг, ИТХ 9,561.0 мянган төгрөгөөр буюу нийт 129,617.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол ЗДТГ 90,518.0 мянган төгрөгөөр, ИТХ 11,063.0 мянган төгрөгөөр, Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийг БЕГ-ын даргад шилжүүлсэн буюу бодлогын өөрчлөлттэй холбоотойгоор боловсролын салбар 96,590.8 мянган төгрөг, соёлын салбар 5,762.8 мянган төгрөг, ЭМТ 168,872.5 мянган төгрөгөөр тус тус бараа материал буурчээ.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл .... сая төгрөг болж, өмнөх оноос .... сая төгрөгөөр өссөн/буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,186.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3,899.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>5,029.42</b>	<b>1,185.13</b>	<b>(3,844.29)</b>
Барилга, байгууламж, орон сууц	4,262.81	841.60	(3,421.21)
Авто-тээврийн хэрэгсэл	90.69	48.51	(42.19)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	268.12	89.51	(178.61)
Тавилга, аж ахуйн эд хогшил	173.38	35.13	(138.25)
Зам, гүүрийн байгууламж	89.47	85.76	(3.71)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	-	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20.21	20.19	(0.02)
Бусад үндсэн хөрөнгө	67.78	64.43	(3.35)
Дуусаагүй барилга, байгууламж	-	-	-
Ном	56.96	-	(56.96)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>56.48</b>	<b>1.72</b>	<b>(54.76)</b>
Программ хангамж	6.41	1.72	(4.69)
Бусад биет бус хөрөнгө	50.07	-	(50.07)
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	-	-	-

Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	-	-	-
<b>Дүн</b>	<b>5,085.90</b>	<b>1,186.85</b>	<b>(3,899.05)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

ЗДТГ-т 73,074.4 мянган төгрөгөөр тус үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол холбогдох дээд байгууллагын шийдвэрээр ЗДТГ 88,396.5, ИТХ 16,634.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийг БЕГ-ын даргад шилжүүлсэн буюу бодлогын өөрчлөлттэй холбоотойгоор боловсролын салбар 3,241,945.9 мянган төгрөг, соёлын салбар 180,787.1, ЭМТ 1,344,080.2 мянган төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгө буурчээ.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2.4 сая төгрөг болж, өмнөх оноос 144.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>138.95</b>	<b>2.36</b>	<b>(136.59)</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	0.47	-	(0.47)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	127.98	-	(127.98)
Зээлийн хүүгийн өглөг	2.29	2.29	(0.00)
<b>Бусад өглөг</b>	<b>8.21</b>	<b>0.08</b>	<b>(8.13)</b>
Байгууллагад төлөх өглөг	7.98	-	(7.98)
Хувь хүмүүст төлөх өглөг	0.23	0.08	(0.15)
Татварын өглөг /ТӨҮГ/	-	-	-
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	-	-
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>147.16</b>	<b>2.44</b>	<b>(144.72)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2,362.5 мянган төгрөг байна. Үүнээс Сум хөгжүүлэх сангийн Зээлийн хүүгийн өглөгт 2,285.0 мянган төгрөгийн, Сум хөгжүүлэх сангийн Хувь хүмүүст төлөх өглөг 77.5 мянган төгрөгийн өр байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,980.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,230.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,007.29	614.78	(1,392.51)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,120.07</b>	<b>880.36</b>	<b>(239.71)</b>
Өмнөх үеийн үр дүн	575.61	4,885.93	4,310.32
Тайлант үеийн үр дүн	544.46	(4,005.57)	(4,550.03)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,083.35	485.52	(2,597.84)
<b>Дүн</b>	<b>6,210.71</b>	<b>1,980.65</b>	<b>(4,230.06)</b>

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Засгийн газрын хувь оролцоо өмнөх оны үлдэгдлээс 57.7 хувиар буурсан нь дээр дурдсан боловсрол, соёлын төсвийг хариуцах эрх шилжсэнтэй холбоотой буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны VI/06 тоот тогтоолоор сумын 2022 оны төсвийг 1,855,102.2 мянган төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 239,057.2 мянган төгрөгөөр, аймгаас олгох санхүүжилт 856,252.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 158,045.6 мянган төгрөг, ОНХС-гаас олгох шилжүүлэг 856,252.5 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 158,045.6 мянган төгрөг, 2022 оны малын хөлийн татвараас сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах дүн 100,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 29-ны IX/01 тоот тогтоолоор сумын 2022 оны төсвийг тодотгон 1,921,115.0 мянган төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 207,611.9 мянган төгрөгөөр, ОНХС-гаас олгох шилжүүлэг 161,853.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 469,301.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 158,045.6 мянган төгрөгөөр, 2022 оны малын хөлийн татвараас сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах дүн 200,125.1 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,374,762.4 мянган төгрөг, ОНХС-гаас 161,853.3 төгрөг, үйл ажиллагаанаас 52,922.1 төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3.1 сая төгрөг, СХС-аас 39,900.0 мянган төгрөгийн зээл төлөгдөж, орлого 148,564.8 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,364,620.0 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 556,500.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлө-гөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	80.06	73.95	6.11	92.4
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	860.33	509.61	350.71	59.2
3	Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт	571.82	372.23	199.59	65.1
4	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	61.87	61.80	0.07	99.9
5	Соёл урлаг	26.30	26.30	0.00	100.0
6	Сургуулийн өмнөх боловсрол	38.80	38.79	0.01	100.0
7	Ерөнхий боловсрол	281.93	281.92	0.01	100.0
	<b>Нийт</b>	<b>1,921.11</b>	<b>1,364.62</b>	<b>556.50</b>	<b>93.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Аудитын илрүүлэлт:

- Багийн засаг дарга гарт үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмын 1.2 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна./ЗДТГ/
- ИТХ-ын даргад үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан журмыг зөрчсөн.

- Багийн иргэдийн нийтийн хурал даргалагч нарын урамшууллыг холбогдох анхан шатны баримтгүй хавтгайруулан олгосон нь анхан шатны баримтгүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 -д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудит нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.
- Сумын зам даваа засварын ажлын төсөвт өртөгт тусгагдсан актаар тогтоогоогүй магадалшгүй ажлын зардал 1,041.8 мянган төгрөг, захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн ажлын баримтгүй, ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж байгууллагад захиалагчийн хяналтын зардал 1,041.8 мянга, зохиогчийн хяналтын зардал 520.9 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.13, 3.19, 4.1-д заасан заалт, Барилгын тухай хуулийн 38.1.4, 38.1.8, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.13, 3.19, 4.1-д заасан заалтыг тус тус зөрчсөн байна.
- “Өрх” ХХК-тай байгуулсан зураг төсвийн ажлыг одоог хүртэл хүлээ аваагүй тул гэрээнд заасны дагуу ажлыг хугацаандаа хийж гүйцэтгээгүй ажилд 136.8 мянган төгрөгийн “Есөн мөнх сүлд” ХХК-тай байгуулсан ариутгалын дүк автомашиныг хугацаандаа хүлээлгэн өгөөгүй тул гэрээнд заасны дагуу ажлыг хугацаандаа хийж гүйцэтгээгүй дүнд 314.4 мянган төгрөгийн алданги тооцоогүй.
- Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заагаагүй 2 төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн./Цагдаагийн автомашин -19,000.0, цагаа идээ боловсруулах цэг-12,000.0/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-д заасныг зөрчин 500.0 мянган төгрөгийн нормын хувцас авсан.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д заасны дагуу төсвийн болон байгууллагын хөрөнгөөр 1000.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйл худалдан авах; тэтгэвэрт гарсан ажилчдад олгосон тэтгэмж олгосон.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.17 дахь заалтыг зөрчин байгууллагын төсвөөр 192.0 мянган төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 81,877.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сайхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ний өдрийн 01/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,921,115.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,816.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

#### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сайхан сумын ТТЗ нь шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

##### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01/836 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	31,500.0	1	31,500.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>31,500.0</b>	<b>2</b>	<b>31,500.0</b>	<b>100</b>

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд анхаарах.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд<sup>1</sup> 2 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 43,483.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 9,965.6 мянган төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоож, 33,517.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн байна.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

###### Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 54.4.5 дахь заалтын дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.4.5 дахь заалтын дагуу тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлэх.

##### 2. Орлого

###### Илрүүлэлт:

2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 148,546.8 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д заасан заалттай бүрэн нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Цаашид орлогын төлөвлөгөөний төлөвлөлт түүний биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр биелүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2						2					
<b>Дүн</b>	<b>2</b>						<b>2</b>				-	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
											-
											-
<b>Дүн</b>											-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
											-
											-
<b>Нийт дүн</b>											-